

# ЭРХ ЧӨЛӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ НАМ

2024.04.12

Улаанбаатар

Батлав: ЭЧХН-ын Боловсруулан Зөвлөлдөх Ерөнхий Хороо

## УРИА: ХҮЧИРХЭГ МОНГОЛЫГ БҮТЭЭНЭ.

Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Нам 2024 оны Монгол Улсын Их хурлын сонгуульд оролцох мөрийн хөтөлбөрөө Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хуулийн 19,4; намын дүрмийн 6.5.12 дох заалтын үндэслэн мөрийн хөтөлбөрийн бодлогыг төлөөллийн байгууллага болох Боловсруулан Зөвлөлдөх Ерөнхий Хороогоор батлав. Үүнд:

- Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэхийн төлөө тууштай байж зорилгоосоо буцахгүй ажиллана.
- Монголын ард түмний эрх ашигт харшилсан хуулиудыг хүчингүй болгож, иргэд, байгууллагын хуулийн төслийн тухай саналыг дэмжиж ажиллана.
- Монгол Улсын хөгжлийн өвөрмөц загварыг хэрэгжүүлэхийн тулд шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хууль эрх зүйн орчинд өөрчлөлт оруулна.
- Хүний эрх, үүрэг, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эх дотооддоо ч гадаадад ч хамгаалан ажиллана.
- Хүүхэд, залуучуудад уламжлалт түүхэн өв соёл, эх оронч боловсрол олгох хөтөлбөрийг хэрэгжүүлж, оюуны өмчийг хөгжүүлнэ.
- Иргэдийн эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлэн агаарын бохирдлыг арилгахын тулд олон тулгуурт эрчим хүчийг ашиглаж, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах зорилгоор иргэдийн хяналтын тогтолцоог бий болгох эрх зүйн орчинг бий болгоно.
- Төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг үр хүүхэд, хойч үедээ нандигнан өвлүүлэх ажлыг бага наснаас нь сургаж хэвшүүлнэ.
- Дотоодын аж ахуйн нэгж, гадаадын хөрөнгө оруулагчдын татварын тогтолцоонд улс эх орны эрх ашигт нийцсэн эрх зүйн орчинг бий болгоно.
- Хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж ард түмэндээ хэрэглээ болгон, эх орондоо хэвшүүлэн хөгжүүлнэ.

НАМЫН ДАРГА



Ш.ТӨМӨРСҮХ